

1. Төслийн хураангуй

Бритиш Колумбийн Их Сургуулийн Норман Б.Кийвил уул уурхайн инженерийн дээд сургууль, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС), Энх Мөнх Эргэх Холбоо (ЭМЭХ) бичил уурхайн ТББ-тай хамтран, ЭМЭХ бичил уурхай ТББ-ын гишүүнүүдийн дунд “КОВИД-19-ийн цар тахал бичил уурхай эрхлэгчдийн нийгэм, эдийн засгийн байдалд үзүүлж буй нөлөөг тодорхойлох” үнэлгээний ажлыг хийлээ. Энэхүү төслийг Дэлхийн Банкны дэргэдэх Extractives Global Programmatic Support (EGPS) санхүүжүүлсэн болно. Энэхүү үнэлгээ нь цар тахал эмэгтэй бичил уурхайчдад хэрхэн нөлөөлсөнийг тодорхойлох байв.

“ЭМЭХ” бичил уурхайн ТББ нь 2008 оны 6-р сард Монгол Улсын Төв аймгийн Заамар суманд бичил уурхай эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бусад талуудтай хамтрах, хэлэлцээр хийх зорилгоор байгуулагдсан. Одоогийн байдлаар “ЭМЭХ” нь 129 гишүүнтэй бөгөөд үүнээс 89 нь эмэгтэй гишүүд байна.

Судалгааны нэгдсэн тайланд “ЭМЭХ” бичил уурхайн ТББ-ын гишүүд оролцсон онлайн санал асуулгын үр дүн, “ЭМЭХ”-ийн 20 эмэгтэй гишүүдтэй хийсэн ярилцлага, 7 эмэгтэй бичил уурхайн эрхлэгч оролцсон фокус бүлгийн уулзалтын дүнгийн тайлбар, МГТИС-ийн оюутан, багш ажилтантай хийсэн уулзалт, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, орон нутгийн бичил уурхай эрхэлдэг төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн уулзалт, олон талуудыг оролцуулсан цахим хурлын талаар нэгтгэн бичсэн болно.

Цахим санал асуулгыг 2021 оны 02-р сарын 22-оос 03-р сарын 18-ны хооронд явуулсан бөгөөд 75.8% -ийн гүйцэтгэлтэй байлаа. Санал асуулгын бүх асуултанд нийт 69 хүн бүрэн гүйцэд хариулсан болно. Энэхүү санал асуулга нь 31 асуултаас бүрдсэн бөгөөд бичил уурхайчдын хүн ам зүй, хөдөлмөрийн мөн чанар, эдийн засаг, нийгмийн нөлөөллийн талаархи мэдээллийг цуглуулсан. Судалгаанаас харахад Төв аймгийн Заамар суманд бичил уурхай эрхэлж буй эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын уршгаар нийгэм, эдийн засгийн хүнд нөхцөл байдалд орсон, олон бэрхшээлтэй тулгарч, одоо ч тулгарсаар байна.

Бичил уурхай эрхэлж буй эмэгтэйчүүдийн дийлэнх нь таваас дээш жил ажиллаж байгаа нь бичил уурхай түр зуурын ажил биш, эмэгтэйчүүд гэр бүлээ тэжээхийн тулд бичил уурхай эрхлэдэг, тэдний орлого бичил уурхайгаас ихээхэн хамаардаг байна. Судалгаанд оролцогчдын 90% бичил уурхайгаас олж буй орлого тэдний гэр бүлийн орлогын 50% -иас багагүй хувийг бүрдүүлдэг гэж хариулсан. 69 оролцогчоос 38 эмэгтэй оролцогч хоёр буюу түүнээс дээш хүнийг өөрийн асрамжанд байдаг гэж хариулсан.

Цар тахлын улмаас орлоггүй болсон нь эмэгтэйчүүдийн бие даасан байдал, гэр бүлээ тэжээх чадварт нөлөөлж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдсэн, эдгээр эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн байна. 4 оролцогч тутмын 3 нь гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдсэн гэж мэдэгдсэн. Тиймээс бие махбодийн аюулгүй байдлыг санхүү, хүнсний тусламжийн хэрэгцээтэй зэрэгцүүлэн хамгийн чухлын нэг гэж мэдэгдсэн. 50 эмэгтэй (73.53%) сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн гэдгийг илэрхийлсэн, энэ бол сэтгэл түгшээсэн зүйл юм. Энэ хүнд нөхцөл байдал тэдний гэр бүлд ихээхэн нөлөөлж байна.

Бичил уурхай эрхэлдэг эмэгтэйчүүдийн асрамж халамжинд олон хүмүүс байдаг, үүний дийлэнх нь насанд хүрээгүй хүүхдүүд байна. Бичил уурхай эрхлэх журмыг түдгэлзүүлсэн (газар олголтыг зогсоосон) нь бичил уурхайн үйл ажиллагааг албажуулахад сөрөг үр дагавар үзүүлж байна. Хууль ёсны гэрээгүй бичил уурхайчид маш хүнд байдалд байна. Орлого олохын тулд тэд талбай руу очиж бичил уурхай хийдэг, тэгснээрээ эрүүгийн хэрэгт буруутгагдаж, торгуулж шийтгүүлдэг байна.

Санал асуулгаас гарсан эдгээр дүгнэлтийг “ЭМЭХ” бичил уурхайн ТББ-ын 20 эмэгтэй гишүүдтэй хийсэн ярилцлагаар баталгаажуулсан болно. Эдгээр ярилцлагууд КОВИД-19-ийн үзүүлж буй нийгэм эдийн засгийн нөлөөг илүү гүнзгий ойлгох боломжийг олгосон. Ганцаарчилсан ярилцлага нь 4-р сарын эхний хоёр долоо хоногт хийсэн бөгөөд 12 асуултаас бүрдсэн байсан. Яагаад бичил уурхайн ажил хийдэг вэ? гэсэн асуултад нийтлэг хариултын нэг нь бусад ажлын боломж хомс байгаатай холбоотой байв. (ярилцлага өгсөн хүмүүсийн 60% нь хариулсан). Судалгаанд хамрагдсан бусад хүмүүс (25%) нь Заамар сумын харьяат бол ажилд орох магадлал бага, бусад нь мэргэжилгүй ба нас өөр ажилд орох гол бэрхшээл гэж хариулсан.

Бүх оролцогчид КОВИД-19-ийн нөлөөнд маш их өртсөн гэж хариулсан. Бичил уурхачдийн орлого огцом буурсан нь тэдэнд тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг гэж мэдээлсэн. Цар тахлын үеэр үндэсний хэмжээнд тогтоосон журам, хязгаарлалтын үр дүнд замууд хаагдаж, хот доторх болон хот хоорондох хөдөлгөөнийг хорьж хязгаарласан. Энэ нь бичил уурхай эрхлэх боломжийг хаасан, тиймээс орлоггүй болсон. Бичил уурхай эрхлэгчид, уул уурхайн томоохон компаниуд болон орон нутгийн засаг захиргааны хооронд байгуулсан гурван талт хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх нь уурхайчдын өнөөгийн ажлын нөхцөл байдлыг шийдвэрлэх боломж гэж нэгэн дуугаар бичил уурхайчид хэлж байсан. Бичил уурхайн газрын асуудал бас нийтлэг дурдагдаж байсан, КОВИД-19-ийн үеэр бичил уурхайчдад орон нутгийн болон үндэсний засгийн газруудаас үзүүлэх тусламжийн төрлүүдийн талаархи нийтлэг санал юу вэ гэсэн асуултад газрын асуудлаас гадна бусад ажил эрхлэлт, санхүүгийн болон хүнсний дэмжлэгийг нэмэгдүүлэх хамгийн түгээмэл хариулт байв. Ерөнхийдөө ярилцлагын хариултууд нь санал асуулгын үр дүнг бататгаж, бичил уурхай эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл, тэдэнд шаардлагатай байгаа дэмжлэгийн талаар нэмэлт ойлголт өгсөн.

“ЭМЭХ” ТББ-ын гишүүд оролцсон фокус бүлгийн уулзалтыг 04-р сард хийсэн. Фокус бүлгийн уулзалтын зорилго нь тэдэнд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх боломжит шийдлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд бусад талуудын гүйцэтгэж болох үүрэг ролийг тодорхойлоход оршиж байв. Фокус бүлгийн уулзалтын үеэр гурван үндсэн шийдлийг тодорхойлж хэлэлцэв. Үүнд: гурван талт гэрээ (орон нутгийн засаг захиргаа-уул уурхайн компани-бичил уурхайн ТББ), хаягдсан уул уурхайн талбай дээр байгаль орчны нөхөн сэргээлт хийхийг зөвшөөрөх, Заамар сумын иргэдэдтэй бичил уурхайн газрын гэрээ хийх. “ЭМЭХ” ТББ-ын гишүүд уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа дуусахад нөхөн сэргээлт хийдэггүй, түүнчлэн орон нутгийн засаг захиргааны зүгээс дэмжлэг дутмаг байгааг мэдэгдэв. Судалгааны үр дүнг тоймыг дор дурдсан 5-р сард зохион байгуулсан цахим уулзалтуудаар дамжуулан холбогдох байгууллага, хүмүүс өргөн хүрээнд түгээж танилцуулсан.

Судалгааны үр дүнг өргөн хүрээнд түгээх, танилцуулах зорилгоор өөр өөр байгууллагуудтай цахим уулзалтуудыг зохион байгуулав. Эхний цахим уулзалтыг 2021 оны 04-р сарын 17-ны өдөр МГТИС-ийн оюутан болон багш ажилтануудад зориулж зохион байгуулсан. Энэхүү хурлын зорилго нь ирээдүйн уул уурхайн инженерүүд болох бакалавр болон магистрийн оюутнуудад мэдлэг болгох зорилгоор бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдал, бичил уурхай эрхлэгчдийн нийгэм эдийн засгийн байдлыг таниулах, бичил уурхай эрхлэж буй шалтгаан, байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөлтийн талаар мэдээлэл өгсөн уулзалт байв. Энэхүү уулзалтанд UBC-ийн профессор Берн Клайн бичил уурхайд хэрэглэдэг байгаа техник, тоног төхөөрөмж, тэр дундаа хүдэр боловсруулах, мөнгөн усгүй технологийн талаар илтгэлийг тавьсан. Судалгааны баг, КОВИД-19 цар тахал нь Заамар сумын бичил уурхай эрхлэгч эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлсөн талаар судалгааны дүнг танилцуулсан. Уг уулзалтанд нийт GMIT-ийн 40 оюутан, багш ажилчид оролцов.

Хоёр дахь цахим уулзалтыг Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (МБУНДХ)-той 2021 оны 04-р сарын 28-ны өдөр хамтран зохион байгуулав. Уг уулзалтаар судалгааны үр дүнг танилцуулахаас гадна Заамар суманд хийсэн судалгааны дүн бусад аймаг сумын бичил эрхлэгчдийн хувьд ижил төстэй эсвэл өөр нөхцөл байгаа эсэх талаар яриа үүсгэх зорилготой байв. Цахим уулзалтын ярилцлагын үеэр бусад бүс нутгуудад ижил төстэй бэрхшээл тулгарч байгаа нь тодорхой болов. Цахим уулзалтанд Баянхонгор, Увс, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Ховд, Дархан Уул аймгуудын бүсийн бичил уурхай эрхлэгчдийн ТББ-уудыг төлөөлж нийт 16 хүн оролцов. Уулзалтаар ерөнхийдөө, бичил уурхай эрхлэх газрын асуудал, өөр ажлын байртай болох боломж, бичил уурхай эрхлэгчдийн хүүхдүүдийн сурч боловсрох боломжийн талаарх асуудлууд хөндөгдөж байв. Бичил уурхай эрхлэгчдийн хамгийн санаа зовж буй асуудлын нэг чухамдаа тэдний хүүхдүүдийн ирээдүй асуудал судалгааны санал асуулга, ярилцлага, фокус бүлгийн ярилцлагад дурдагдаж байсан сэдэв юм.

Хамгийн сүүлийн гурав дахь цахим хурлын арга хэмжээ 2021 оны 5-р сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан. Энэхүү цахим хуралд олон талын оролцогчдыг урьж оролцуулсан байгаа. Энэхүү цахим хурлын зорилго нь төслийн үр дүнг оролцогчдод танилцуулах, судалгааны дүнг хуваалцах мөн судалгаанд хөндөгдсөн асуудлаар хэлэлцэх явдал байв. Энэхүү арга хэмжээнд нийт 25 байгууллагын төлөөлөл болох 40 хүн оролцсон, маш сайн ирцтэй хурал байв. Үүнд: УИХ-ын гишүүд, Герман, Канадын ЭСЯ, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Заамар сумын Засаг дарга, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Жендэрийн үндэсний хороо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачид, иргэний нийгмийн байгууллага болон бичил уурхай эрхлэгчдийн ТББ-д оролцов.

Судалгааны баг нь судалгааны үр дүнг өргөн хүрээнд түгээж, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч болон олон улсын хамтын нийгэмлэг, иргэний нийгмийн анхааралд хүргэж чадлаа. Цахим хурлын хэлэлцүүлгийн гол сэдэв нь бичил уурхайн эрх зүйн орчин, бичил уурхай эрхлэгчид, уул уурхайн компаниуд болон нутгийн захиргааны

байгууллагуудын гурван талт гэрээ хэлэлцээр, бичил уурхайн газар олголтын талаар байв. Цахим уулзалтанд оролцсон УИХ-ын гишүүн судалгааны дүнг парламентад танилцуулах түүнчлэн ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хэлэлцүүлэгт оролцохыг урив.

Цахим уулзалтаас гадна, Монголын уул уурхай сэтгүүлийн 05-р сарын дугаарт UBC судалгааны төслийн удирдагчтай хийсэн судалгааны үр дүнгийн талаар хийсэн ярилцлага нийтлэгдсэн. Монголын уул уурхай (The Mongolian Mining Journal) сэтгүүл нь хоёр хэлээр хэвлэгдэн гардаг, сардаа 1500 гаруй уншигчдад хүрдэг. Үүнээс гадна уг сэтгүүлийг Dow Jones 'Factiva сувгаар цахим хэлбэрээр бас авч унших боломжтой. Ярилцлагын онлайн хувилбарыг 06-р сарын дундуур уг сэтгүүлийн вэбсайт дээр байрлуулж, нэмэлт үзэгчдэд хүргэх болно.

Судалгааны төслийн үр дүнг онцолсон, Заамар сумын бичил уурхай эрхлэгчдийн Энхмөнх Эргэх Холбоо ТББ-ын Тэргүүнтэй хийсэн ярилцлагыг багтаасан хоёр дахь нийтлэлийг 6-р сард IKON News-д нийтлэх болно.

Энэ төслийн хураангуйг өргөн хүрээнд түгээх болно. Үүнд: Монгол Улсын уул уурхайн салбартай холбоотой асуудал эрхэлсэн байгууллага болон уул уурхайн салбартай холбогдох бусад байгууллага, агентлагууд байна.

Судалгааны дүнгээс харахад бичил уурхайн талаарх мэдээлэл хоорондоо зөрүүтэй, бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж буй бүс нутагт бичил уурхайн салбарын судалгаа дутмаг байгаа харагдаж байна. Олон талт оролцогчдын хурлын үеэр бичил уурхайн үйл ажиллагаатай бүс нутагт нэмж судалгаа хийх хэрэгтэй гэсэн санал байв, энэ санал нь бичил уурхай эрхэлдэг ТББ-уудтай хийсэн хурлын үеэр ч мөн гарсан санал байв. Заамар суманд хийсэн кейс судалгаагаар Ковид-19-ийн үеэр бичил уурхайн нөхөрлөлүүдэд тулгарч байсан бэрхшээлийн талаар тодорхой ойлголттой болсон боловч бусад аймгуудад энэхүү нөлөөллийн үнэлгээг хийснээр нийт бичил уурхай эрхлэгчдийн байдлын талаар бодит мэдээлэлтэй болох бөгөөд бичил уурхай эрхлэх журмыг шинэчлэн боловсруулж буй үед тодорхой бодит мэдээлэл өгөх боломжтой.

Судалгааны дүнд үндэслэн гурван талт хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгсөн байгаа. Урьд нь “Бичил уурхайчдын ТББ, уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргаа” гэсэн гурван тал оролцсон гэрээг хийж байсан туршлага байна. Энэхүү гурван талт гэрээ нь бичил уурхайчдын хувьд чухал ач холбогдолтой, учир нь энэхүү гэрээ бичил уурхайчдыг албан ёсны хэлбэрээр ажиллах, уул уурхайн компаниудтай хамтрах боломжийг бий болгодог байна.

Хоёрдахь зөвлөмж нь бичил уурхай эрхлэгчид болон орон нутгийн төр захиргааны байгууллага, ЖДҮ эрхлэгчид, үндэсний засгийн газар, уул уурхайн компаниудын хооронд яриа өрнүүлж, хэлэлцээр хийх асуудал. Энэхүү яриа хэлэлцээрийг олон улсын байгууллагын дэмжлэг, тусламжтайгаар холбогдох талуудыг оролцуулан хийх боломжтой.